БАТЛАВ

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ДЭНЗЭН

АТА13730 7082201
9024101314

20.25. оны .05. сарын .09. өдөр

АЖЛЫН ДААЛГАВАР

Захиалагч:	Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ
Судалгааны нэр:	Generation Z үеийн залуучуудын сэтгэл зүйн онцлог
Судалгааны ажлын хүрээ:	1997-2010 онд төрсөн Монгол улсын иргэнийг хамруулна.
Судалгааг гүйцэтгэх хугацаа:	Хуанлийн 30 хоног

Судалгааны ажлын үндэслэл:

Нийгэм, соёл, техник технологи, эдийн засаг, экологийн өөрчлөлтүүдийн үр дүнд нэг цаг үед амьдарч буй хүмүүс нийтлэг нэг хэв шинжтэй болж, нийгмийн сэтгэл зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай болсноор нийгмийн үе үүсдэг. Дэлхийн нийт хүн амын 1/3-ийг “Generation Z” үеийнхэн бүрдүүлж байгаа тул тэдний сэтгэлгээний хэв маяг, шийдвэр гаргалт, үнэт зүйл, нийгмийн оролцоо зэргийг дэлхийн бусад улс орнууд онцлон анхаарч, судлах болсон. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 42 оронд хийсэн судалгаагаар Европ ба Америкт амьдардаг залуус өөрсдийнхөө амьдрал ба ирээдүйд хамгийн ихээр сэтгэл хангалуун бус байдаг ажээ. Мөн "Generation Z" үеийнхний хамгийн анхаарал татсан шинж тэмдгүүдийн нэг бол тэд сэтгэл зүйн эрүүл мэндийн өвчин, сэтгэл санааны гутралд өртөмтгий байдал юм. Учир нь "Generation Z" үеийн залуучуудын ажилд хандах сэтгэл зүйн онцлог өвөрмөц бөгөөд тэд “Хөдөлмөрийн харилцаа”-н дахь шатлан захирах ёсны талаар өөр үзэл бодолтой, Нэг ажил дээрээ тогтвор суурьшилтай, удаан ажиллах сонирхол дутмаг, уян хатан, үнэт зүйлсэд нь тохирсон, зорилгодоо хөтлөгдсөн ажлын байрыг эрхэмлэдэг, анхаарал төвлөрөл, бүтээмж багатай байна. Бие болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлын хувьд өмнөх үеийнхнээсээ сул, ажил, амьдралын тэнцвэрт байдалд ихээхэн анхаарал хандуулж, хувийн сайн сайхан байдлаа эрхэмлэдэг.

Монгол Улсын хувьд "Generation Z" үеийн залуучуудын ялгаатай байдлын тухай хийгдсэн судалгаа ховор бөгөөд хөдөлмөрийн насны залуу үеийн төлөөлөл болсон "Generation Z" үеийн залуучуудын ажлын байран дээрх хандлага, зан төлөвийн асуудал нь ажил олгогчид, хөдөлмөрийн зах зээлд оролцогч субъектүүдийн анхаарал татсан асуудал болоод байна.

Судалгааны зорилго, ач холбогдол:

1997-2010 онд төрсөн "Generation Z" үеийн залуучуудын сэтгэл зүйн онцлог болон зан төлөв, ажилд хандах хандлагыг судалж, суурь судалгааны сан бүрдүүлэхэд чиглэнэ. 2040 он гэхэд нийт хөдөлмөрийн зах зээлийн 43 хувь нь "Generation Z" үеийнхэн бүрдүүлэхээр хүн амын төсөөлөл байгаа учраас тэдний сэтгэл зүйн онцлог, зан төлөв, хандлагын талаарх судалгаа чухал ач холбогдолтой болно.

АТА13730 7082201
9024101314

Судалгааны баримтлах арга зүй:

1. Бодлогын судалгааны арга зүйг баримталж, тодорхой асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбар боловсруулахад чиглэгдэнэ.
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.26-д заасан нөхцөл байдлын дүн шинжилгээг хийнэ.
3. Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тогтоосон асуудлыг шийдвэрлэх хөгжлийн загвар, төсөөлөл, үр нөлөө, гарах үр дүн, нөөцийн судалгаа, санхүүгийн хэмжээ, эх үүсвэрийн тооцоолол хийж, бодлогын хувилбарыг боловсруулна.
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.27-д заасан нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийнэ.
5. "Generation Z" үеийн залуучуудын сэтгэл зүйн онцлогийн талаар хийгдсэн гадаад, дотоодын улс орнуудын онолын болон бусад судалгааны тайлан, өгүүлэл, бодлогын баримт бичигт анализ хийж өөрийн оронд тохирсон бодлогын шийдэл боловсруулах.
6. "Generation Z" үеийн залуучуудын ажилд хандах хандлага, ажлын байрнаас хүлээх хүлээлт, цалин хөлсөнд хандах хандлага, багаар ажиллах чадвар, нийгмийн оролцоо зэргийг тодорхойлох зорилгоор тоон судалгаа авна.
7. "Generation Z" үеийн залуучуудын хөдөлмөрийн харилцаан дахь сэтгэл зүйн бэлэн байдал, хандлага, ур чадварыг үнэлэх зорилгоор ажил олгогчидтой ярилцлага хийнэ.
8. Хот суурин болон хөдөө орон нутгийн "Generation Z" үеийнхнийг ажиглаж, гол онцлог, ялгааг тодорхойлно.
9. Бие хүний зан төлөвийн онцлог, харилцааны хэв маяг, тэсвэр тэвчээр, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэр зэргийг сэтгэл зүйн тестээр судалж, сэтгэл зүйн оношилгоо хийнэ.
10. Судалгааг боловсруулах нарийвчилсан арга зүй, аргачлалыг судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан судалгааны баг сонгоно.

Судалгааны ажлын хүрээнд гүйцэтгэх ажлууд:

- "Generation Z" үеийн залуучуудын сэтгэл зүйн онцлогийн талаар хийгдсэн гадаад, дотоодын улс орнуудын онолын судалгаанд дүн шинжилгээ хийж, судлагдсан байдлын тойм боловсруулах, бодлогын шийдэл санал болгох;
- "Generation Z" үеийн залуучуудад чиглэсэн бодлогын баримт бичиг болон хууль, эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийнэ.
- Зориулалтын танхимд сэтгэл зүйн тест ашиглаж, оношилгоо хийх;
- Судалгааны ажилд ашигласан дата, тоон мэдээллийг цахим хэлбэрээр ирүүлэх;

- Судалгааны ажлын тайланг хэвлэлийн шаардлагад нийцүүлэн 4 хувь хэвлүүлэн цаасан болон цахим хэлбэрээр ирүүлэх (Формат: B5 (176 x 250 мм), нүүрний тоо: 200-220, хэвлэлийн технологи: Офсет хэвлэл, Цаасны төрөл: 105-127 гр/м² шохойтой цаас, Өнгө: 4+4 (CMYK), Хавтасны материал: 250-300 гр/м² мат бүрэлттэй, шохойтой цаас, лакан түрхлэгтэй, Хавтасны өнгө: 4+4 (CMYK), Дотоод хэвлэлийн өнгө: 4+4, Нуруу: Наалттай, Хэвлэлтийн тоо: 4 ширхэг)
- Санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

Судалгааны ажил гүйцэтгэгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвараа тайлагнадаг хуулийн этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Багийн бүрэлдэхүүн хамгийн багадаа 5 судлаач байх ба 4-өөс доошгүй судлаач нь мэргэжлийн сэтгэл зүйч, социологич, сэтгэл судлаач байх,
2. Судалгааны багийн ахлагч нь их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас дээш жил ажилласан, олон улсын төсөлд багийн ахлагч, судлаачаар ажиллаж байсан ажлын туршлагатай, докторын зэрэгтэй байх;
3. Багийн гишүүд нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр олон улсын итгэмжлэгдсэн боловсролын байгууллагад магистр буюу түүнээс дээш түвшний боловсролын зэрэг хамгаалсан байх.
4. Багийн гишүүд их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, үндэсний болон олон улсын төсөлд судлаачаар ажиллаж байсан ажлын туршлагатай байх.

Судалгааг гүйцэтгэх, ажлын тайланг хүлээн авах хугацаа:

Д/Д	Тайлан	Захиалагч талд хүлээлгэн өгөх хугацаа	Тайлангийн агуулга
1	Эхлэлийн тайлан:	Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор	-Судалгааны ажлыг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, судалгааны аргачлал, судалгааны маягт, онолын судалгааны тойм
2	Дунд хугацааны тайлан:	Гэрээ байгуулснаас хойш ажлын 17 хоногийн дотор	- Бодлогын баримт бичиг болон хууль, эрх зүйн баримт бичигт хийсэн дүн шинжилгээ - Тоон судалгааны урьдчилсан тайлан - Чанарын судалгаа болон сэтгэл зүйн оношилгооны урьдчилсан тайлан

3	Эцсийн тайлан:	Гэрээ байгуулснаас хойш ажлын 22 хоногийн дотор	-Өмнөх судалгааны тайланд захиалагчаас өгсөн санал, зөвлөмжийг тусган ахин танилцуулах -Судалгааны үр дүнгийн нэгдсэн тайланг захиалагчид танилцуулж санал, зөвлөмжийг тусган хүлээлгэн өгөх -Судалгааны мэдээллийн нэгдсэн санг хүлээлгэн өгөх

---oOo---